



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/28

Хэрлэн сум

Сонгон шалгаруулалт зохион
байгуулах комисс томилох

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.3, Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 67 тоот тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 2.17, 2.18 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах орон нутгийн комиссын гишүүнийг сонгон шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Баярмаа Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Д.Долгоржав Нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч


Д.Өнөрцэцэг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Л.Мэндбаяр Эрүүл мэндийн газрын дарга

Ж.Цэнджав Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/166 дугаар “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулж, гишүүдийг удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга бөгөөд комиссын дарга /Ц.Баярмаа /-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010109